

**“МИК Холдинг” ХК-ийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл**

Хурал болсон газар: Шангри-Ла зочид буудал, 1 давхар, Нью-Йорк хурлын танхимд

Хурал болсон он, сар, өдөр: 2019 оны 4 дүгээр сарын 29-ний Даваа гараг

Хурал болсон цаг: 10 цаг 20 минут

Хурлын дарга: Мягмар овогтой Мөнхбаатар

Хурлаар хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
2. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
3. ТУЗ-ийн 2018 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай
4. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
5. 2019 оны ТУЗ-ийн зардлын төсвийг батлах.

Хурлын ирц: 90 хувь

Хуралд биечлэн болон урьдчилан саналын хуудсаар оролцогчид:

№	Хувьцаа эзэмшигчдийн нэр	Энгийн хувьцааны тоо ширхэг	Ирц
1	Б.Баттулга	1	0.00001%
2	Д.Адьяахүү	1	0.00001%
3	Ц.Цэцгээ	10	0.00007%
4	Д.Байлхүү	295	0.00193%
5	Д.Янжмаа	2	0.00001%
6	Б.Мөнхтулга	2	0.00001%
7	Ж.Баатар	3	0.00002%
8	Д.Оюунцэцэг	1	0.00001%
9	Б.Цэрэнжав	16	0.00010%
10	Д.Анхбаяр	2	0.00001%
11	П.Нямдорж	1	0.00001%
12	Л.Өнөржаргал	1	0.00001%
13	Г.Халиунаа	3	0.00002%
14	Д.Батсайхан	1	0.00001%
15	А.Чулуун	1	0.00001%
16	Б.Интернационал	1,436	0.00942%
17	BDSEC	27	0.00018%
18	Капитрон банк	210,621	1.38140%
19	Хас банк	210,621	1.38140%
20	"Ти Ди Би Капитал" ХХК	1,552,726	10.18389%
21	НЕКСУС ФИНАНС	129,998	0.85262%
22	ХХБанк	2,069,000	13.56998%
23	УБ Хотын банк	3,536,662	23.19596%
24	Стандарт инвестмент	2	0.00001%
25	Голомт банк	1,023,699	6.71415%
26	Азиа дайверсифайд рийл истэйт фонд нэг ХХК	1,875,000	12.29759%
27	Монгол улсын хөгжлийн банк	3,081,955	20.21366%

Хуралд оролцсон албан тушаалтан:

1. Э.Шижир, “МИК Холдинг” Х-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн;
2. Б.Гантулга, “МИК Холдинг” ХК-ийн Гүйцэтгэх захирал;
3. З.Мөнх-Оргил, “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-ийн Тэргүүн дэд захирал;
4. Б.Булган, Санхүү, төлөвлөлт шинжилгээний хэлтсийн захирал;
5. Х.Батхишиг, Олон нийттэй харилцах хэлтсийн мэргэжилтэн;
6. Д.Гансүх, Мэдээлэл технологийн хэлтсийн ахлах мэргэжилтэн.

М.Мөнхбаатар: “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Хурлыг нээхтэй холбогдуулан тооллогын комисс ирцээ танилцуулна уу.

С.Амарсайхан: Сайн байцгаана уу? Та бүхэнд хурлын ирцийг танилцуулъя. “МИК Холдинг” ХК-ийн 2019 оны 4 дүгээр сарын 29-ний хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт 10,269, 217 ширхэг буюу нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 67 хувийн ирцтэй байна.

М.Мөнхбаатар: Баярлалаа. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд ирсэн та бүхэнд баярлалаа. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар үндсэн 5 асуудлыг хэлэлцэнэ. 1. Компанийн 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай; 2. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай; 3. ТУЗ-ийн 2018 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай; 4. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай; 5. ТУЗ-ийн 2019 оны зардлын төсвийг батлах тухай гэсэн асуудлууд байна. Гүйцэтгэх захирал компанийн үйл ажиллагаа үр дүнгийн талаар товч танилцуулга хийнэ. Үүний дараа миний бие болон гүйцэтгэх захирлаас асуух асуулт байвал асууж болно.

Б.Гантулга: Өглөөний мэнд. Намайг Гантулга гэдэг. “МИК Холдинг” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар жил хагас ажиллаж байна. Анх удаа хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хүмүүс байгаа тул компанийн товч танилцуулгыг хийе. “МИК Холдинг” ХК-ийн доор “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК гэж байна. Тусгай зориулалтын компани байгуулах замаар арилжааны банкуудаас орон сууцны зээлийг үнэт цаасжуулалт хийдэг. Компани нь анх 2006 онд үүсгэн байгуулагдсан. 2005 онд Засгийн газрын зүгээс Монгол улсад орон сууцны санхүүжилтийг тогтвортой хөгжүүлэх зөв бүтцийн талаар олон улсын санхүүгийн байгууллагад хандаж байсан. Үүний дагуу USAID гэдэг байгууллагаас орон сууцны зах зээлийг хөгжүүлэхийн тулд хоёрдогч зах зээлийн үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн байгууллага хэлбэрээр явах нь оновчтой гэсэн зөвлөмжийг өгсөн 2006 онд Монголбанк 10 арилжааны банк санамж бичиг байгуулж улмаар 9 сард тус “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-г байгуулж байсан. Тус компани нь өөрийн хөгжлийн үе шатыг туулаад 2011 онд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хуулийг баталсан. Компанийн онцлох үйл явдал гэвэл 2015 онд нээлттэй компани болж Монгол улсын хөрөнгийн бирж дээр хамгийн өндөр дүнтэй IPO хийсэн компани болж байсан. Өнөөдрийн байдлаар нийт хувьцаа эзэмшигчдийн тоо 120 гаруй болсон. Компанийн үндсэн зорилго нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган дотоод, гадаад хөрөнгийн зах зээл дээр борлуулах замаар ипотекийн анхдагч, хоёрдогч зах зээлийг хөгжүүлж, Монгол Улсын хүн амыг орон сууцаар хангах, цаашид орчин үеийн хот байгуулалтыг эрчимжүүлэхэд чиглэсэн урт хугацаат санхүүжилтийн тогтолцоог бий болгож төлөвшүүлэхэд оршино. Мөн 2018 оны сүүлээр 305 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй болж Хөрөнгийн биржийн TOP- 20 индекст орсон. Зээлжих зэрэглэлийн үнэлгээг өнгөрсөн оноос хийлгэж тогтмол хийлгэж ирсэн. Монгол улсын зээлжих зэрэглэлтэй адил үнэлгээ авсан. Компанийн бүтцийн хувьд “МИК Холдинг” ХК нь 3 охин компани үүсгэн байгуулсан. “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК нь арилжааны банкуудаас

орон сууцны зээл авахдаа буцаах нөхцөлтэй болон буцаахгүй нөхцөлтэй худалдан авалт хийх гэсэн 2 замаар авдаг. Протеги Фөрст ХХК, МИК Рийл Эстейт ХХК гэсэн охин компани 2018 онд үүсгэн байгуулсан бөгөөд одоогоор үйл ажиллагаа явуулж эхлээгүй судалгаа хийж байна. Хувьцаа эзэмшигчдийг бүтцийн хувьд 20 хүртэлх хувийг төрийн байгууллага эзэмшдэг. Аж ахуйн нэгж байгууллагууд 80.6 хувийг эзэмшиж байна. Үүнээс арилжааны банкууд 37 хувийг эзэмшиж байна. Үлдсэн хувийг хувь хувьцаа эзэмшигчид эзэлж байна. Хувьцаат компанийн хувьд нийт 52 удаагийн арилжаа хийгдэж 5,049 ширхэг хувьцаа арилжаалагдсан бөгөөд 31 тэрбум төгрөгийн багцын арилжаа хийгдсэн байна. Оны онцлох үйл явдлаас дурдвал нийт 5 удаа 580.5 тэрбум төгрөгийн баталгаат бонд гаргасан. МИК ба сэтгүүлч арга хэмжээг байнга зохион байгуулдаг. Мөн утаагүй Улаанбаатар форумыг зохин байгуулж утаагүй болгох нэг шийдэл нь иргэдийг орон сууцжуулах байж болно гэсэн шийдлээр хэлэлцүүлэг хийсэн. Мөн Барилга хот байгуулалтын яам, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран “Азийн тогтмол орлоготой үнэт цаасны 5 дахь удаагийн чуулга уулзалт”-ыг Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Бизнесийн үндсэн үйл ажиллагааны хувьд буцаах болон буцаахгүй нөхцөлтэйгөөр худалдан авалтыг хийдэг. Энэ худалдан авалт нь орон сууцны санхүүжилтэд ямар ач холбогдол өгдөг вэ гэхээр арилжааны банкууд portfolio менежмент хэргэлдэг бөгөөд тухайн багцыг тодорхой хувь дээр барьдаг. Буцаахгүй нөхцөлтэй зээлийг худалдан авснаар арилжааны банкуудад дахин 8 хувийн зээл гаргах орон зайг бий болгож байна. Буцаах нөхцөлтэй багцын хувьд банкуудын хөрвөх чадварыг сайжруулах мөн банкуудын богино хугацаатай эх үүсвэрийг аль болох олон жилээр сунгах боломж олгож байна. Санхүүгийн үр дүнгийн хувьд өөрийн хөрөнгийг 208 тэрбум төгрөгт хүргэсэн. Нийт цэвэр хүүгийн өгөөж 3.2 хувтай, нийт хөрөнгийн өгөөж 1.9 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 31 хувтай байна. 2019 онд худалдан авалтын үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн буцаах нөхцөлтэй 876 тэрбумын багц авах, буцаахгүй нөхцөлтэй 427 тэрбумын багц авч, ИЗББ гаргах гэсэн төлөвлөгөө байна. Мөн орон сууцнаас бусад төрлийн зээлийн багцыг худалдан авах боломжийг судалж байна. Мөн банк бус санхүүгийн байгууллагуудтай хамран ажиллах боломжийг судалж байна. Цаашид зайлшгүй хийх ажил бол ногоон бонд ногоон санхүүжилтийн эх үүсвэрийг татах асуудал байна. Эрсдэлийн удирдлагын стандарт тогтоолгох, баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

М.Мөнхбаатар: Тус танилцуулгад ороогүй мэдээллийг та бүхэнд өгье гэж бодлоо. 2019 оны эхээр ашигт ажиллагаа болон эрсдэлд нөлөөлөхүйц үйл явдал болсон. Загийн газрын ямар нэгэн баталгаагүй 300 сая долларын хөрөнгийн олон улсын зах зээлд босгосон. Үүнийг Монголбанктай урт хугацаанд ярьсны үндсэн дээр Swor хэлцэл хийж төгрөг болгосон. Буцаах нөхцөлтэй багц худалдах эх үүсвэр болж байна. Бонд босгосны давуу тал гэвэл компани цаашдаа Монголбанк, Сангийн яамны эх үүсвэрийн ашиглаж хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргадаг байсан бол өөрийн эх үүсвэр татаж орон сууцны зах зээлд хувь нэмрээ бие даан оруулж ирсэн. Монгол төгрөгөөр бодвол 780 орчим төгрөгийн эх үүсвэр орж ирсэн. Гол зорилго гэвэл 8 хувийн эх үүсвэрт ордоггүй 80 метр квадратаар хязгаарлахгүй зах зээлийн хүүтэй зээлийн багцыг авахаар төлөвлөж байна. Дараагийн үйл явдал бол манай харилцагч болох Капитал банк эрх хүлээн авагч томилсон. 8 хувийн эх үүсвэрийг хэрэгжүүлдэг банкуудын нэг бөгөөд үүнтэй холбоотой мөнгөн урсгалын эрсдэл бий болж байна. Энэ эрсдэлийг хаахаар Тусгай зориулалтын компани бүр дээр байдаг нөөц хөрөнгөөр эрсдэлийн хаана. Мөн Монголбанктай сайн хэлэлцээр хийж байна. Капитал банк нь үйлчилгээ үзүүлдэг банк байсан. Иймд 8 хувийн зээл маань аль нэг арилжааны банкууруу шилжихээр байна. Удахгүй хоёрдогч банкруу шилжүүлэх хүрнэ. Та бүхэнд 2018 онтой холбоотой асуулт байвал Гантулга захирал бид 2 хариулна.

Нэгдүгээр асуудал: Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай.

Компанийн жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах тухай тогтоолыг уншиж танилцуулъя. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах тухай Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 96 дугаар зүйлийн 96.1, 96.5, 96.6 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.2.1 дэх заалт, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.7.15, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийг тус тус үндэслэн “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тогтоох нь: 1. “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийн гаргасан 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй. 2. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй. 3 Энэ тогтоолын 2-т заасан тайланг аудитын дүгнэлтийн хамт холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэн байгууллагад хүргүүлэн хувьцаа эзэмшигч болон олон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн ажлын алба (Г.Саруул)-д үүрэг болгосугай. 4. Энэ тогтоолын 2-т заасан тайланг ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийн хамт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж зохих шийдвэрийг гаргуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (М.Мөнхбаатар)-д даалгасугай. 5. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, аудитын хороо (Э.Шижир)-нд үүрэг болгосугай. Энэ тогтоолтой холбоотой асуух асуулт байна уу?

Б.Интернационал: Өнгөрсөн 2 жилийн хугацаанд ногдол ашиг хуваарилаагүй. Цаашид компани ногдол ашгийн ямар бодлого барих вэ? Бага дүнгээр ногдол ашиг хуваарилаад явж байвал хувьцаа эзэмшигчдэдээ компанийн зах зээлийн үнэлгээ нэмэгдэж эерэг нөлөө үзүүлнэ гэж харж байна.

М.Мөнхбаатар: Өнгөрсөн 2017, 2018 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилаагүй. Үндсэн шалтгаан гэх юм бол 2018 оноос эхлээд олон улсын зах зээл дээр бонд гаргах үйл ажиллагаа эхэлсэн. Түрүүн мэдээллийн чанартай та бүхэнд дурдсан бөгөөд энэ ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн. 2018 онд ногдол ашиг хуваарилаагүй шалтгаан бондын бэлтгэл ажилтай холбоотой ногдол ашиг хуваарилаагүй. Олон улсын зах зээл дээр бонд гаргахад өөрийн хөрөнгийн хүрэлцээ асуудал байсан. 2019 онд аливаа олон улсын бондын Stand alone буюу ямарваа нэгэн Засгийн газар болон зохицуулагч байгууллагын баталгаагүй гаргасан учраас ногдол ашиг хуваарилах асуудал дээр бонд төлөгдөж дуусах хугацаанд хуваарилахыг хориглодог олон улсын стандарт байдаг. 2020 мөн бондын гэрээний дагуу ногдол ашиг хуваарилахааргүй байна. Гэхдээ 2022 онд бонд mature болсны дараа ногдол ашиг хуваарилах боломжтой болно. 2022 оноос ногдол ашиг бондын гэрээний дагуу хуримтлагдаж явж байгаад хязгаарлалт байхгүй хуваарилагдаж эхэлнэ.

Б.Цэрэнжав: Капитал банк манай хувьцааг эзэмшдэг байсан. Монголбанкнаас гаргасан шийдвэрийг авах хэрэгтэй байна. Ер нь бол Капитал банкныг дампуурсан гэж харахгүй байна. Өнөөдөр шүүхийн шийдвэр банкны тухай хуулиар хуулийн шийдвэрээр банк дампуурсныг заралдаг гэх ганцхан өгүүлбэр байдаг. Өнөөдөр ямар ч хуулийн байгууллага Капитал банкныг дампуурсан гэж зарлаагүй. Монголбанк төлбөр тооцооны асуудлыг бидэнд мэдээлэх хэрэгтэй гэж бодож байна. Мөн ТУЗ-ийн дарга өөрөө хариулах хэрэгтэй. Жилд 12 удаа үнэхээр хуралдаж байна уу? Уучлаарай сайхан цалинтай байна. Би улиралд нэг удаа хуралдаад асуудлыг шийдэж болох байх гэж харж байна. Дотор нь ажилладаггүй учраас ачааллыг нь сайн мэдэхгүй байна. Мөн нэгж хувьцааны үнэлгээний дээшлэхгүй байна. 10 мянган төгрөгөөс дээш гарахгүй байна. Ханшны бодлогын талаар тайлбар хийнэ үү?

М.Мөнхбаатар: Капитал банктай холбоотой асуудал дээр компанийн зүгээс илүүтэйгээр Монголбанкны байр суурь яригдах байх. Энэ асуудал дээр тодорхой хариулт өгөх боломж бага байна.

Өнөөдрийн байдлаар 2 төрлийн гэрээ байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны гэрээг арилжааны банкууд болон Монголбанктай хийж харилцаа зохицуулагддаг. Мөн үйлчилгээ үзүүлэх гэрээгээр харилцаа зохицуулагддаг. Бидний хүлээгдэж байгаагаар ойрын хугацаанд үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу Капитал банк дээр байгаа 8 хувийн зээл хоёрдогч банкуу шилжинэ. Энэ ажлыг шийдвэр гарснаас хойш гүйцэтгэх удирдлага Монголбанктай уулзаж ойлголцолд хүрсэн. Ажлын хэсэг гараад ажиллаж байна. Хугацааг нь хэлэх боломжгүй. 1707 зээлдэгчийн мэдээллийг шалгаад Монголбанктай ойлголцолд хүрсэн. Богино хугацаанд зээлийг өөр банкуу шилжүүлэх ажлыг хийгээд явж байна. Үйл ажиллагаанд ямар нэгэн эрсдэл үзүүлэх нь бага гэж үзэж байна. Дээр дурдсан ямарваа нэг эрсдэл бий болбол хуримтлагдсан нөөц хөрөнгөөр хаах боломжтой. 12 удаа хуралдсан гэж албан ёсоор бичсэн боловч биетээр болон цахимаар хурлууд хийгдэг. Ажлын ачааллын хувьд ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлыг оруулаагүй. Хороод 2018 онд бондтой холбоотой олон асуудал хэлэлцэгдэж анх удаа зэрэглэл тогтоолгох, олон улсын аудитын байгууллагаар улирал болгон тайлангаар гаргаж явсантай холбоотой. Мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас 5 удаа гаргасантай холбоотойгоор байнгын ТУЗ-ийн үйл ажиллагаа явагдаж ачаалалтай байдаг. Гэхдээ компанийн үйл ажиллагаа засаглал талаас ингэж явахаас өөр аргагүй. Олон улсын санхүүгийн байгууллагуудтай засаглалын хөтөлбөрийг хэрэгжүүлээд эхэлсэн. ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын хүрээнд урьдчилсан байдлаар зөвлөмжөө авсан бөгөөд манай ТУЗ-ийн үйл ажиллагаа олон улсын стандартын дагуу явж байна гэсэн дүгнэлтэд хүрсэн. Нэгж хувьцааны ханш дээшээ явахгүй байгаа шалтгаан нь нэгж хувьцааны үнэлгээ өндөр байгаатай холбоотой байх. Өнгөрсөн жил бондтой холбоотой үйл ажиллагааг анхаарч байсан учраас өмнөх Хувьцаа эзэмшигчдийн хурлаар санал болгож байсан хувьцааг хуваах үйл ажиллагааг хийж амжсангүй. Энэ жил судлаад боломж байдал хувьцааг хуваах юм бол хувьцааны идэвх нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна.

Б.Даваадорж: Өргөтгөсөн хөрөнгө оруулалттай холбоотой хөтөлбөрийн зээлд санхүүжилт хийхэд хүндрэлтэй байдал үүсэж байна. Бондын эргэн төлөлт болон тухайн жилийн төсөвт тусгагдсан дүнгээс санхүүжүүлнэ гэсэн байсан. Цаашид хөтөлбөрийн санхүүжилтийг багасгах уу? Компанийн үйл ажиллагаанд яаж нөлөөлөх вэ? Дараагийн асуулт нь олон улсын зах зээлээс 300 сая төгрөгийн бонд гаргаад зах зээлийн хүүтэй зээл худалдаж авахад зориулна гэсэн байна. Цаашид дахин олон улсын зах зээлд бонд гаргаад явах боломж хэр байна вэ?

М.Мөнхбаатар: Сая 8 хувийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн журамд өөрчлөлт орсон. Арилжааны банкуудын оролцоог нэмэгдүүлсэнтэй холбоотой 8 хувийн зээл өөрөө гаргалт буурсан. Монголбанкнаас олгодог эх үүсвэр удаашралтай байна. Хэдийгээр Монголбанкнаас 230 тэрбум төгрөг, төсөвт 115 тэрбум төгрөг суулгасан боловч арилжааны банкуудад төсвөөс ямар нэгэн эх үүсвэр олгоогүй. Үүнтэй холбоотой тус хөтөлбөр удаашралтай байна. Бидний харж байгаагаар 1 дүгээрт 8 хувийн эх үүсвэр дээр байгаа 4 орчим тэрбум төгрөг бол нэмэгдэхгүй. Тийм шалтгаанаар 1 сард амжилттай болсон 300 сая долларын бондыг босгосон. Компанийн үйл ажиллагааг илүү өөр эх үүсвэр босгож зах зээл дээр байршуулснаар орон сууцны зээлийг түлхүү гаргах анхны боломжит алхмыг хийсэн. Компанийн ашигт ажиллагаанаас шалтгаалаад үргэлжлүүлэх бодол байна. Энэ бондын онцлогийг дурдах нь зүйтэй. Манайхтай ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг компаниудаас дэлхийд анх удаа stand alone нөхцөлөөр дэлхийд анх удаа бонд гаргаснаар онцлог. Азид 2 удаа бонд гаргасан тохиолдол байна. Эхний удаа Малайзын housing corporation гаргасан бөгөөд энэ нь төв банкныхаа 100 хувийн баталгаатай гаргасан. Мөн Солонгос улсын housing corporation бонд гаргасан нь Засгийн газрын 100 хувийн баталгаатай гаргасан. Манай бондын том ялгаа нь Засгийн газрын баталгаагүй гарснаараа онцлог. Бидний хүлээлт гэх юм энэ бондын мөнгийг зөв байршуулах юм бол дараа дараагийн өндөр хүүтэй байгаа орон сууцны зээлийн хүүг бууруулах боломжтой гэж харж байна. Өнөөдрийн Монголбанкны Swap-ийн хүүд нэлээд өндөр төлж байна. Хүүг бууруулах талаар ажиллаж байна. 8 хувийн хөтөлбөрийг хэрхэн идэвхжүүлж бүрдүүлэх тал дээр холбогдох яамнуудтай уулзаад явж байна.

- А.Чулуун: 8 хувийн хөнгөлөлтэй зээл ардчилсан намын ялалтын үед бий болсон. Олон олгогдон зээлийн дотор зээлээ төлөх чадваргүй иргэд байдаг. Орон сууцаа хураалгах гэж байгаа зүйл мэдэгдэхгүй байна. Америкийн нэгдсэн улсад нэг өвгөн захалгааны мөнгөө төлж чадахгүй болоод ямар нэгэн буулт хийгээгүй төлсөн. Хэрэв тэр хүнд буулт хийн юм бол бүгдэд нь буулт хийх юм бол бүгдэд нь буулт хийх болно. Зах зээлийн хуулиар ипотекийн зээлийн хүүг буурах ёсгүй ямар нэгэн этгээд засгийн зээлийг завших бололцоо байх ёсгүй. Ипотекийн зээлээ төлж чадахгүй болсон бол нэр хүнд унана гээд улсын хөрөнгийг завших бололцоо олгоод байна гэж бодож байна.
- Б.Гантулга: Америкт нэгдсэн улсын санхүүгийн зах зээлийн хөгжил бол Монгол улстай харьцуулахад өөр. Хамгийн том ялгаа нь Монгол улсын иргэн орон сууцны зээл авахдаа өөрсдөө амьдрахаар авдаг. Америкийн зах зээл дээр болж байсан хямралын гол шалтгаан нь орон сууцыг хөрөнгө оруулалтын чиглэлээр ихээр худалдан авч байсан. Бид нар олон улсын валютын сангийн хөтөлбөрийн хүрээнд чанаргүй болсон зээл харьцуулахад орон сууцны зээлийн чанаргүй болсон нь 8 дахин бага хувьтай байна. Гол дүгнэлт нь манай орны хувьд одоохондоо тийм хэмжээний хямралд өртөхөөр асуудал бага. Улаанбаатар хотын нийт өрхийг аваад үзвэл 60-65 хувь нь гэр хороололд амьдардаг. Компанийн зүгээс хотын утааг бууруулахтай холбоотой төрөөс явуулж байхад иргэдийн орон сууцжуулах орон зай байна гэж харж байна. Бид нар дунд болон дараагийн 5-10 жилд орон сууны зах зээлийн санхүүжилт талыг сайн хөгжүүлэх юм бол дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувьд хүргэх боломж харагдаж байна. Энэ хөтөлбөр нь өөрөө сайн хамгаалттай байх хэрэгтэй. Иргэд маань өөрөө 30 хувийн урьдчилгааг төлж байна гэдэг нь дэлхийн бусад оронтой харьцуулахад бага бас Засгийн газар нь төрийн албан хаагчдаа зориулаад өөр төрлийн бүтээгдэхүүн мөн гаргадаг. Монгол улсын хувьд өөр байдаг. 30 хувийн урьдчилгаа өр орлогоо харьцаа 45 хувиас дотогш байх ёстой гэсэн хязгаарлалт нь сайн хамгаалалт болж өгч байна.
- Б.Интернационал: Ногдол ашгийг өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхэд ашиглах гэсэн тайлбар хийж байна. Жил тутам халаасны хувьцаа өсөж байна. Халаасны хувьцааг эзэнтэй болгох ажил хийж өөрийн хөрөнгийг өсгөх боломж байна. Мөн 300 сая долларын бонд гаргасан гэж байна. Энэ бонд нь 1 удаагийн татан авалтаар юм уу 2022 он хүртэл ногдол ашиг хуваарилахгүй, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх байх шат дараатай үүрэг хүлээсэн юм уу? Ямар үндэслэлээр 2022 он хүртэл гэж заасан бэ?
- М.Мөнхбаатар: Эхний асуудлыг буруу ойлгосон байна. Бондтой холбоотой ногдол ашиг хуваарилахгүй байна. 2 дугаарт халаасалж байгаа хувьцааг олон улсын AAA зэрэглэлтэй компанид худалдахаар яриа хэлэлцээр хийгдэж байна. Харамсалтай нь AAA зэрэглэлтэй компани нь ихэнхдээ хөгжлийн банкууд байдаг учраас шийдвэр гаргалтын процесс удаан байна. Эхний алхам нь бонд гаргахаас гадна эдгээр компаниудтай ажиллахын тулд зээлжих зэрэглэл тогтоолгосон. 2 дугаарт засаглалын хөтөлбөр хэрэгжүүлж байна. Шалтгаан нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалсан шийдвэр гаргадаг эсэх мөн жижиг хувьцаа эзэмшигчдийн нөлөөлөлд автахгүй байхад хяналт тавьж байна. Үүний дараагаас хэлэлцээр хийх нөхцөл бүрдэнэ. Энэ оны 2 дугаар хагасаас идэвхтэй хэлэлцээр хийх боломж бүрдэнэ. Энэ бонд нь өөрөө олон улсын Сингапурын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй бонд. Ихэнх хувь нь Азийн зах зээл дээр боссон бөгөөд үлдсэн хувь нь Америк болон европын зах зээл дээрээс боссон бонд юм. Reg S 144A стандартын дагуу гаргасан. Энэ стандартын дагуу Indenture гэрээний заалтыг уншиж танилцуулъя. Баталгаа гаргагч, Компани, тэдгээрийн бүрэн өмчилж буй охин компаниас бусад этгээдийн эзэмшиж буй Баталгаа гаргагч, Компани, түүний охин компаниудын гаргасан энгийн хувьцаанд (Баталгаа гаргагч, Компани тэдгээрийн охин компанийн хувьцаанд (disqualified хувцаа болон давуу эрхийн хувьцаанаас бусад) төлбөл зохих ногдол ашгийн хуваарилалт эсхүл опцион, баталгаа, энгийн хувьцааг эзэмших бусад эрхээс гадна) аливаа ногдол ашгийг төлөх, хуваарилах, түүнийг зарлах гэж байна. Бондын талаарх мэдээллийн МИК Холдинг ХК-ийн вэб сайтаас авч болно. Олон улсын хөрөнгө оруулагчдад зориулж сайтад тусгай цэс гаран мэдээлэл тавьж байна. Дахиад нэг асуулт аваад ал

- П.Нямдорж: Бусад үзүүлэлт сайжирсан мөртөө ашигт ажиллагаа муудсан. Бондын хүү хэдэн хувьтай байна. Зээлийн ханшийн эрсдэлийн бууруулж төгрөгт шилжүүлсэн. Энэ талаар тайлбар өгнө үү?
- М.Мөнхбаатар: Ашигт ажиллагаа “Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК- дээр буурсан. Үндсэн шалтгаан мөн бондтой холбоотой. 2018 оны 4 сард бонд гаргах хүлээлттэй байсан бол зах зээлийн шалтгаанаар хойшилсон. Үндсэндээ 2017 оны 12 дугаар сарын тайлан болон 6 сар, 9 дүгээр сарын 31-ны байдлаар аудит хийлгэсэн. Бондтой холбоотой зардал өндөр гарсан тул ашигт ажиллагаа буурсан. Бондын хүү 9.75 хувийн хүүтэй гарсан. Дараа дараагийн бонд дээр Монгол улсын эдийн засаг болон зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалаад хүү буурах гэсэн хүлээлттэй. Монголбанктай хийсэн хэлцлийг арилжааны банкаар дамжуулан орсон. Давуу нөхцөл аваагүй арилжааны банкуудтай Swap хэлцэл хийдэг нөхцөлөөр хийсэн. Хүү нь өндөр 4 орчим хувийн хүүг зөвхөн зардалд төлж байна.

Хоёрдугаар асуудал Ногдол ашигын талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай

- М.Мөнхбаатар: Та бүхэнд шийдвэрийг уншиж танилцуулъя. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5, 46.6 дахь хэсэг, “МИК Холдинг” ХК-ийн дүрмийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэг, “МИК Холдинг” ХК-ийн “Ногдол ашигын бодлого”-ын 3 дугаар зүйлийн 3.3, 3.5 дахь хэсгийг тус тус үндэслэн “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тогтоох нь :1. “МИК Холдинг” ХК-ийн 2018 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай. 2. Энэ тогтоолын 1-т заасан шийдвэрийн үндэслэлийг компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл М.Мөнхбаатарт үүрэг болгосугай. 3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн ажлын алба Г.Саруулд үүрэг болгосугай.

Гуравдугаар асуудал: ТУЗ-ийн 2018 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай

- М.Мөнхбаатар: Компанийн тухай хууль болон Компанийн дүрмээр олгосон ТУЗ-ийн бүрэн эрхийн хүрээнд 2018 онд тус компанийн ТУЗ-ийн 12 удаагийн хурлаар нийт 32 шийдвэрийг гаргаж, олон улсын сайн жишгийг нэвтрүүлэхтэй холбоотой санаачилгуудыг дэмжиж ажиллаа.2018 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас баталсан голлох шийдвэрүүдийг танилцуулъя. Компанийн үндсэн зорилго, зорилтод нийцүүлэн компанийн засаглалтай холбоотой бодлого, журмуудыг шинэчлэн баталсан. Олон улсын зах зээлд үнэт цаас гаргах , МИК Групп компанийн 2018 оны бизнес төлөвлөгөө, дунд хугацааны стратеги болон 2019-2020 оны төсөөллийг батлах, Компанийн үйл ажиллагааг төрөлжүүлж, цаашид ашгийг нэмэгдүүлэх зорилгоор охин компаниудыг үүсгэн байгуулсан. Мөн МИК Групп компанийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх, сайжруулах зорилгоор “Комплаенсын бодлого”-ыг анх удаа баталсан.ТУЗ-ийн хороод нь компанийн засаглалын зөв бодлого, зарчмыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдол өгч ажилладаг.ТУЗ нь өөрийн үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх зорилготой байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагаа явуулах ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Үйл ажиллагаа, эрх зүйн хороо болон Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо гэсэн 4 хороотой үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр хороод нь компанийн засаглалын зөв бодлого, зарчмыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдол өгч ажилладаг.2018 онд ТУЗ-ийн дэргэдэх хороод нь үндсэн чиг үүргийн хүрээнд компанийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, дотоод аудитын нэгжийг удирдан чиглүүлэх, дотоод үйл ажиллагааны дүрэм, журмыг сайжруулах, компанитай байгуулах гэрээ хэлцэл, зээлийн багц худалдан авахтай холбоотой эрсдэлийг тодорхойлохтой холбоотой дүгнэлт гарган ажиллаа. Та бүхэнд асуулт байна уу?
- Ж.Баатар: Миний бодлоор ногдол ашиг хуваарилахгүй мөн хувьцааны хувьд өөрчлөлт алга. Иймд ТУЗ-ийг сайн ажиллахгүй байна гэж үзэж байна. Би цалинг багасгах саналтай байна. Цалинг багасгах юм бол ажлаа сайн хийж ногдол ашиг хуваарилах талаар бодох байх. 2

жил ногдол ашиг өгсөнгүй. Хувьцааны үнэ өссөнгүй. Ногдол ашиг өгөөд хувьцааны үнэ өсөөд ирвэл цалингийн хэмжээг өсгөж болно.

М.Мөнхбаатар: Шүүмжлэлийг хүлээж авлаа. Хувьцаа эзэмшигчийн бүрэн эрх байна. Саналын хуудсаар та саналаа өгч болно.

Дөрөвдүгээр асуудал: Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

М.Мөнхбаатар: Дүрмийн өөрчлөлтийн асуудлыг тараагдсан материалд тодорхой тусгагдсан байгаа тул танилцуулах шаардлагагүй гэж үзээд асуулт байвал хариулахад бэлэн байна. Нийт 24 өөрчлөлт орсон бөгөөд үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдөөгүй бөгөөд хаяг өөрчлөгдсөн мөн редакцын өөрчлөлтүүд орсон. Асуулт байхгүй бол дараагийн асуудлыг танилцуулъя.

П.Нямдорж: Дүрмийн 21.7 дэх хэсэгт ямар асуудлыг дийлэнх олонхоор хэлэлцэж ямар асуудлыг олонхоор шийдэж байна вэ? 24.1 дэх хэсгийг бас тайлбарлаж өгнө үү? 24.7 дах хэсгийг мөн 26.3 дах хэсэгт мөн тайлбар өгнө үү?

М.Мөнхбаатар: 21.7 дах хэсэгт Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг ТУЗ-ийн хэлцэл хийх сонирхолгүй хараат бус гишүүдийн олонхийн саналаар гаргана гэсэн байна Энэ нь компанийн тухай хуулийн 92.4-т сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах тухай төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөлийн хэлцэл хийх талаар сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхийн саналаар, хувьцаат компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн олонхийн саналаар гаргана гэж заасантай нийцүүлсэн. Дараагийн 26.3 дах хэсэгт ижил төрлийн хувьцаа бүрийн хувьд нэгж хувьцааны ногдол ашгийн дүн нь хувьцаа бүрийн хувьд адил байна гэсэн нь нэг өгүүлбэрт агуулга нь давхацсан байна. Дараагийн заалт нь Компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид санал нэгтгэйгээр шийдвэрлэнэ гэдгийн хассан бөгөөд агуулгын хувьд давхардсан дүрмийн 4.2 дах хэсэгт шинээр нэмвэл 4.1 дэх хэсэгт бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар шийдвэрлэнэ гэж заасантай агуулгын хувьд адил болохоор байна.

Тавдугаар асуудал: ТУЗ-ийн 2019 оны зардлын төсвийг батлах тухай

М.Мөнхбаатар: “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2019 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн хурлаас “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн цалингийн зардлын төсвийг дараах байдлаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, батлуулах тухай дүгнэлтийг гаргасан. МИК Холдинг ХК-ийн ТУЗ нь “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-өөс гадна “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-ийн ТУЗ-ийн бүрэн эрх, Тусгай зориулалтын компанийн хувьцаа эзэмшигчдийг бүрэн эрх, мөн шинээр үүсгэн байгуулагдсан компанийн ТУЗ-ийн болон Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг мөн хэрэгжүүлэн ажилладаг. Түрүүн хувьцаа эзэмшигч асууж байсан яагаад 12 удаа хуралддаг вэ гэж асууж байсан. Учир нь дээрх компаниудын ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийг давхар хэрэгжүүлдэг. 2018 оны цалингийн төсөвтэй харьцуулахад өсөөгүй. ТУЗ нь өөрөө 9 гишүүнтэй бөгөөд 3 нь хараат бус 6 ердийн гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Асуулт байхгүй бол хурлын дэгийн дагуу 20 минут завсарлаад эргээд уулзъя.

Б.Жаргал: Энэ хуралд анх удаа оролцож байна. Бид нарт өгсөн танилцуулга дээр санхүүгийн тайлан хураангуй байна. Асуулт асуух гэхээр болохгүй байна. Мөн дүрмийн өөрчлөлт дээр асуулт асуух гэхээр дүрэм байхгүй байна. Авч болох уу?

М.Мөнхбаатар: Компанийн сайтад дээр санхүүгийн тайлан дэлгэрэнгүй тавигдсан байна. Орж танилцах боломжтой. Дүрмийн хувьд компанид хандаад авах бүрэн авч болно.

- Б. Жаргал: Сүүлд гаргасан бондтой холбоотой хэдийн хэмжээний зардал гарсан бэ? 1 дүгээр улиралд хэдий хэмжээний зардал гарсан. Бондын эх үүсвэр ямар хэлбэрээр байршиж байна вэ? 2018 онд гүйцэтгэлээр гарсан зардал хэд вэ?
- М.Мөнхбаатар: 2019 оны мэдээллийг сайтад удахгүй байршуулна. 2018 онд бонд болон компанийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Азийн тогтмол орлоготой үнэт цаасны 5 дахь удаагийн чуулга уулзалт”-ыг Улаанбаатар хотноо анх зохион байгуулав. Энэ жил тус холбооны ТУЗ-ийн даргаар ажиллаж байна. Мөн S&P, Moody’s зэрэг байгууллагаар үнэлгээ хийлгэсэн. Бондтой холбоотой гаднын болон дотоодын компаниудаас мэргэжлийн үйлчилгээ авсан. Нийт 6.4 тэрбум төгрөгийн зардал гарсан.
- М.Мөнхбаатар: Эхний асуудалтай холбоотой 19/01 тоот тогтоолын төслийг танилцуулъя. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай 1. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, “МИК Холдинг” ХК-ийн дүрмийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хурлын 19/07 тоот тогтоолыг тус тус үндэслэн “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **тогтоох нь**: 1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлан болон “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийн гаргасан 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга М.Мөнхбаатар. Энэ асуудалтай холбоотой тооллогын комисс дүнг танилцуулна уу?
- С.Амарсайхан: Нийт хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрсөн 13.692,082 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 99.99 хувь зөвшөөрсөн. Татгалзан санал байхгүй. Түдгэлзсэн 2 хувьцаа эзэмшигч буюу 0, 00001 хувь байна. Энэ асуудал хурлын ирц 90 хувьтай.
- М.Мөнхбаатар.: Баярлалаа. Дараагийн хурлаас гарах 19/02 тоот тогтоолыг уншиж танилцуулъя. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “МИК Холдинг” ХК-ийн дүрмийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг тус тус үндэслэн “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас тогтоох нь :1. “МИК Холдинг” ХК-ийн дүрэмд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай. Үүнд: 1.1. Дүрмийн дараах хэсгийг өөрчлөх:
2.2-т “Улаанбаатар хот, Монгол улс, ..., 10-р давхар” гэснийг “Монгол улс, Улаанбаатар хот, ..., 13-р давхар” гэж;
8.3.8-д “Нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;” гэснийг “Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;” гэж;
8.3.9-т “Компанийн өөрийн хувьцаагаар солих,...” гэснийг “Компанийн өөрийг хувьцаагаар солих,...” гэж;
9.4-т “...дахин сонгоно.” гэснийг “...нөхөн сонгоно.” гэж;
9.6-д “ТУЗ-ийн гишүүнийг хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгох...” гэснийг “ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох...” гэж;
9.7.3-т “Компанийн гүйцэтгэх захирлыг сонгох, түүний бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох;” гэснийг “Компанийн гүйцэтгэх захирлыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;” гэж;
16.2-т “Дотоод аудит нь компанийн үндсэн үйл ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүүгийн бүртгэл, эрх зүйн мэдлэг, туршлагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ТУЗ-аас баталсан Дотоод хяналтын хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.” гэснийг “Дотоод аудитын нэгж нь компанийн үндсэн үйл ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүүгийн бүртгэл, эрх зүйн мэдлэг, туршлагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд нэгжийн үйл ажиллагаатай холбоотой журмыг ТУЗ-өөс батална.” гэж;
16.3-т “Компанийн өдөр тутмын удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ-ийн томилсон дотоод аудит нь хэрэгжүүлнэ.” гэснийг “Компанийн өдөр тутмын удирдлагын

үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ-өөс томилогдсон дотоод аудитын нэгж буюу дотоод аудитор хэрэгжүүлнэ.” гэж;
16.4-т “Дотоод аудит нь компанийн ажилтан албан хаагчдын ажлын байранд хэзээ ч нэвтрэх, аливаа мэдээллийг шаардан гаргуулах эрхтэй байна.” гэснийг “Дотоод аудитор нь компанийн ажилтны ажлын байранд хэзээ ч нэвтрэх, аливаа мэдээллийг шаардан гаргуулах эрхтэй байна.” гэж;
16.5-д “Дотоод аудитын албанаас...” гэснийг “Дотоод аудитын нэгжээс...”, Гүйцэтгэх захирлын даалгавраар ТУЗ-ийн тэдний баталсан...” гэснийг “Гүйцэтгэх удирдлагын даалгавраар ТУЗ-ийн баталсан...” гэж;
21.7-д “...дийлэнх олонхын саналаар...” гэснийг “...олонхийн саналаар...” гэж;
24.6-д “Хуваарилахаар шийдвэрлэсэн ногдол ашгийг ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигч бүрээр...” гэснийг “Ногдол ашгаа аваагүй хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг...” гэж. 1.2. Дүрмийн дараах хэсэгт нэмэлт оруулах: 8.4-т “Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:” гэж; 8.3.7-8.3.20 дахь заалтыг 8.4.1-8.4.14 гэж; 9.7.21-т “...чиглэлээр...” гэсний дараа “хараат буюу” гэж; 14.1-т “...ажиллуулж...” гэсний дараа “болох бөгөөд тус хороо нь компанийн хараат буюу охин компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүргийг хэрэгжүүлж, шийдвэр гаргах эрхтэй байна.” гэж. 1.3. Дүрмийн дараах хэсгээс хасах: 8.6.2-т “...тодорхой хугацаа заагаагүй бол...” гэснийг; 14, 14.1, 14.2, 14.4-т тус тус “...дэд...” гэснийг; 15.5-т “...хөлсөөр ажиллах гэрээний...” гэснээс “...хөлсөөр ажиллах...” гэснийг; 16.6.4-т “Аудитын гэрээгээр тодорхойлсон бусад мэдээллүүд.” гэснийг; 22.10-т “Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.” гэснийг; 24.1-т “...хувьцаа бүрийн хувьд...” гэснийг; 24.7-д “Хувьцаат ... гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо...” гэснийг; 26.3-т “Компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид санал нэгтгэйгээр шийдвэрлэнэ.” гэснийг. 2. Энэ тогтоолын 1-т заасан нэмэлт, өөрчлөлтийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлж хянуулах, улсын бүртгэлд бүртгүүлэхийг “МИК Холдинг” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Гантулгад даалгасугай. 3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл М.Мөнхбаатарт үүрэг болгосугай. Энэ асуудалтай холбоотой санал өгсөн байдлыг танилцуулна уу?

С.Амарсайхан: Дүрмийн 1 дүгээр өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан 0.00012 хувь, 2 дах өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, түдгэлзсэн 0.00012 хувь, 3 дах өөрчлөлт дээр 99.99 хувь, татгалзсан санал байхгүй, түдгэлзсэн 0.00012 хувь, 4 дэх өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, түдгэлзсэн 0.00012 хувь, 5 дах өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал байхгүй түдгэлзсэн 0.00012 хувь, 6 дах өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал байхгүй түдгэлзсэн 0.00012 хувь, 7 дах өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал байхгүй түдгэлзсэн 0.00012 хувь, 8 дах өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал байхгүй түдгэлзсэн 0.00012 хувь, 9 дэх өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал байхгүй түдгэлзсэн 0.01 хувь, 10 дах өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал байхгүй түдгэлзсэн 0.01 хувь, 11 дэх өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал байхгүй түдгэлзсэн 0.01 хувь, 12 дах өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал байхгүй түдгэлзсэн 0.00012 хувь, 13 дах өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал байхгүй түдгэлзсэн 0.01 хувь, 14 дэх өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал байхгүй түдгэлзсэн 0.00012 хувь, 15 дах өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал байхгүй түдгэлзсэн 0.00012 хувь, 16 дах өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал байхгүй түдгэлзсэн 0.00012 хувь, 17 дах өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал байхгүй түдгэлзсэн 0.00012 хувь, 18 дах өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал байхгүй түдгэлзсэн 0.01 хувь, 19 дэх өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал

байхгүй түдгэлзсэн 0.00012 хувь, 20 дох өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал байхгүй түдгэлзсэн 0.01 хувь, 21 дэх өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал байхгүй түдгэлзсэн 0.00012 хувь, 22 дах өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал байхгүй түдгэлзсэн 0.00012 хувь, 23 дах өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал байхгүй түдгэлзсэн 0.00012 хувь, 24 дэх өөрчлөлт дээр зөвшөөрсөн 99.99 хувь, татгалзсан санал байхгүй түдгэлзсэн 0.00012 хувь, Нийт 90 хувийн ирцтэй санал өгсөн.

М.Мөнхбаатар: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах 19/03 тоот тогтоолыг уншиж танилцуулъя. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны зардлын төсвийг батлах тухай Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “МИК Холдинг” ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг, “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2019 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн хурлын 3 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас тогтоох нь: 1 “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны зардлын төсвийг Хавсралтад заасны дагуу баталсугай. 2 Энэ тогтоолын Хавсралтаар батлагдсан зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо М.Мөнхбаатарт даалгасугай. Энэ асуудалтай холбоотой санал өгсөн байдлыг тооллогын комисс танилцуулна уу?

С.Амарсайхан: Тооллогын комиссын дүнгээр зөвшөөрсөн 13,692,072 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 98, 45 хувь зөвшөөрсөн. Татгалзан 1,55 хувь, Түдгэлзсэн санал байхгүй байна.

М.Мөнхбаатар: Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд ирсэн та бүхэнд баярлалаа. Манай сайт болон Хөрөнгийн биржийн мэдээлэл хангалттай биш бол компаниас мэдээлэл авах эрх нээлттэй байгаа шүү. Өнөөдрийн хурлыг хаалаа. Баярлалаа.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГА ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:



Г.САРУУЛ
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

М.МӨНХБААТАР
Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга